

Дундговь аймгийн Соёл урлагийн байгууллагуудын 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 20

Мандалговь хот

НЭГ. Дундговь аймгийн Соёл, урлагийн байгууллагуудын 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт хийж, үр дүнг тооцох, тодорхой үр дүнд хүрээгүй, удааширалттай байгаа зорилт арга хэмжээг тогтооход чиглэгдэнэ.

ХОЁР. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр: Соёл, урлагийн байгууллагууд төрөөс соёлын талаар баримтлах бодлогын хэрэгжилт, Монгол улсын Засгийн газрын болон орон нутгийн бодлого шийдвэр, үйл ажиллагааны зорилтуудын хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний дагуу хамгаалж хугацаандаа бүрэн ирүүлсэн. 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Төв Халхын дуулалт жүжгийн театр, Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр, Музей, номын сангийн жилийн эцсийн тайланд үнэлгээний баг үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.1, 6.2.2-т заасан арга зүйгээр үнэлж төсвийн шууд захирагчид хүргэлээ.

ГУРАВ. Үнэлгээний явцад байгууллагууд үр дүнтэй хийж бүтээсэн ажлууд ихээхэн байсан нь харагдаж байна.

-ТХДЖТеатр нь бодлогын баримт бичиг хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд 4 зорилт, 42 арга хэмжээг төлөвлөн өөрийн үнэлгээгээр зорилтын дундаж хувь 100 хувь, арга хэмжээний гүйцэтгэлийн дундаж хувь 98.4 хувь, нийт 99.5 хувьтай гарсан байна.

Цаашид анхаарах асуудлаар: Жилийн эцсийн байдлаар 100 хувь биелэлттэй 4 зорилт 40 арга хэмжээ, үр дүнгүй буюу 0 хувьтай 1 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-99 хувийн гүйцэтгэлтэй 1 арга хэмжээ байна.

үр дүнгүй буюу 0 хувьтай гарсан 1 арга хэмжээ нь театрын шинэ барилгыг барьж ашиглалтад оруулах байсан ба энэ нь төсөв санхүүгийн хувьд хүндрэлтэй, байршилын хувьд тохиромжгүй гэх зэрэг шалтгаанаас царцанги байна.....

Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-99 хувьтай 1 арга хэмжээ нь аймгийн 80 жилийн угтсан киноны ажил энэ нь мөн төсөв санхүүгийн асуудлаас болж удааширсан байна. Ирэх 2023 онд төсөвт тусгагдах үгүй нь шийдэгдээгүй байна.

Цаашид төлөвлөгөө, шалгуур үзүүлэлт, тайланг нягт уялдаатай оновчтой гаргаж ажиллахыг зөвлөж байна.

-Тэнгэрийн тэмдэг нь жилийн эцсийн байдлаар чиг үүргийн хүрээнд 4 зорилт, 38 арга хэмжээг төлөвлөж, 100 хувь биелэлттэй 2 зорилт 34 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-99 хувийн гүйцэтгэлтэй 2 зорилт 4 арга хэмжээ байна.

Цаашид анхаарах асуудлаар: 2.1 Хүүхэд залуучуудын соён гэгээрүүлэх ордны шинэ барилга барьж ашиглалтад оруулах гэсэн ззалтын дагуу барилгын зураг төсөв шинээр хийж техникийн нөхцөл, геологийн дүгнэлт хийгдэж хүлээлгэж

өгсөн ба шийдвэр бүрэн гараагүй байна. Иймд нөхцөл байдлыг шинжилж хүсэлтийг дахин хүргэх хэрэгтэй гэж үзэж байна.

2.2 Бүрдийн уянга хүүхдийн зусланг түшиглэн “Ардын зан үйл амьдрах арга ухаан” хөтөлбөрт сургалт зохион байгуулах дээр сургалт хөтөлбөрөө илүү дэлгэрүүлэн түгээхэд анхаарах хэрэгтэй.

Цаашид зорилт шалгуур үзүүлэлт харилцан уялдаатай, үр дүнд хүрэхүйц байх, тайланг бичихдээ үг үсгийн алдаагүй стандартын дагуу, тоо баримттай үр дүнг түлхүү тусгах хэрэгтэй.

-Музей: Хуулиар олгосон чиг үүргийн дагуу 100 хувь биелэлттэй 9 зорилт 40 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн 70-99 хувьтай 3 зорилт 2 арга хэмжээ, үр дүнгүй буюу 0 хувьтай 1 зорилт 3 арга хэмжээ байна.

Анхаарах: Музейг шинэ барилгын зураг төсөв хийлгэх мөн төсөв санхүү, хэмнэлтийн тухай хуулийн дагуу хасагдсан. Одоогоор санал хүргэх шатандаа явж байна.

Түүх соёлын үл хөдлөх дурсгалын гэрээт хамгаалагчийн цалингийн төсвийг батлуулах дээр хэмнэлтийн тухай хууль гарсанаар зогсонги байна.

Номын сан: Хуулиар олгосон чиг үүргийн дагуу 100 хувь биелэлттэй 7 зорилт 43 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн 70-99 хувьтай 4 зорилт 5 арга хэмжээ байна.

Дүгнэлт:

Аймгийн Засаг даргын гэрээгээр хүлээсэн үүргийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын 6.2.3.2-т заасны дагуу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үзэж байна.

Гэрээгээр хүлээсэн үүргийг байгууллагын болон төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, хэрэгжилт үр дүнг хагас, бүтэн жилээр тооцон хэрэгжилт удаашралтай байгаа болон тасарч болзошгүй заалтуудыг эрчимжүүлэх арга хэмжээ авч байх.

Гэрээгээр хүлээсэн хэрэгжүүлэх арга хэмжээний шалгуур үзүүлэлт нь төлөвлөлтийн баримт бичгийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжихээр төсөлд заасан тоон болон шалгуур үзүүлэлтийг хангахгүй байсан тул хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд хүндрэлтэй байгаа учраас шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг оновчтой тодорхойлж байх саналыг гаргаж байна.

ЗӨВЛӨМЖ БИЧСЭН:
ХШҮ МЭРГЭЖИЛТЭН  Б.НАДМИДЦЭРЭН
ХЯНАСАН:
СУГ-ЫН ДАРГА  Х.ЦОГЗОЛМАА

ДУНДГОВЬ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ДҮГНЭЛТ

2022 оны 12 дугаар сарын 07

Мандалговь хот

Дундговь аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь Соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлж, хүний нөөцийг хөгжүүлэх, түүх соёлын биет болон биет бус өвийн бүртгэл, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, Монгол үндэсний өв соёлыг орон нутгийнхаа онцлогт нийцүүлэн туурвисан шинэ уран бүтээл 2021 онд 8 байсныг 2022 онд 9 болгож нэмэгдүүлэх, Соёл, урлагийн байгууллагуудын орчин нөхцөлийг сайжруулах, Соёл, урлагийн салбарын хөгжлийг тодорхойлох бодлогын баримт бичгийг шинээр болон шинэчлэн боловсруулан хэрэгжүүлэх, Дундговь аймаг, Соёл урлагийн байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойн хүрээнд бүтээлч ажлыг санаачлан зохион байгуулах гэсэн 6 зорилт, 40 арга хэмжээ, 56 шалгуур үзүүлэлт, гэрээний заалт 23, 2 хавсралттайгаар боловсруулсан.

Төлөвлөсөн ажлуудаас бүрэн хэрэгжсэн буюу 100 хувийн биелэлттэй 5 зорилт, 39 арга хэмжээ, үр дүнгүй буюу “0” хувьтай 1 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай буюу 31-69 хувийн гүйцэтгэлтэй 1 зорилт, гэрээний заалтаас 100 хувийн гүйцэтгэлтэй 18, “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-99 хувийн гүйцэтгэлтэй 5 арга хэмжээ байна.

Монгол Улсын Засгийн газрын “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх” нийтлэг журмын дагуу үнэлэхэд дунджаар 97,3 хувьтай дүгнэгдлээ.

“0” хувьтай үнэлэгдсэн буюу хэрэгжээгүй 1 ажлын тухайд шалгуур үзүүлэлтээ буруу томъёолсоноос шалтгаалан хэрэгжих боломжгүй болсон гэж үзсэн. Цаашид олон талаас нь харж чанартай нотлогдохуйц ажил төлөвлөх нь зүйтэй.

Бодлогын баримт бичиг бүрт тусгагдсан барилгын хөрөнгө оруулалттай холбоотой заалт санхүүгийн эх үүсвэрээс шалтгаалж хэрэгжих боломжгүй болсон. Шалтгаан нь төсөв хөрөнгө оруулалттай холбоотой ба хэмнэлтийн тухай хуулийн дагуу дахин шинээр барилга барих эрх хязгаарлагдмал болж байгаа юм. Ингэхлээр 2023 оны төлөвлөгөөнд барилгын зарим ажлыг хасах өөрчлөх нь зүйтэй гэж үзэж байна.

2022 онд зохион байгуулагдсан томоохон ажил, арга хэмжээнээс дурьдвал:

- Аймгийн 80 жилийн ой, Хүний хөгжлийг дэмжих ажлын хүрээнд “Ардын Урлагийн наадам” 108 төрийн албан хаагчид, аж ахуй нэгж байгууллагын дунд 6 төрлөөр зохион байгуулж 1069 авьяастнууд оролцлоо.
- Аймгийн түүхт 80 жилийн ой, Соёл урлагийн салбар үүсгэн байгуулагдсаны 80 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулж 8900 үзэгч сонирхжээ.
- “Нүүдэлчин монгол-2022” соёлын их наадамд нийт 38 биет өвийн төрлөөр 76 ардын авьяастан оролцож дэд байр,
- “Адууны өв соёл” айрагны наадамд 23 төрлийн биет өвөөр үзэсгэлэн гаргаж, 560 гадаад дотоодын үзэгчдэд хүрсэн

- Алдар гавьяат уран зохиолч С.Буяннэмэхийн 120 жилийн ойн хүрээнд 17 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулсан зэрэг олон ажлыг амжилттай зохион байгуулсан байна.

Дээрх арга хэмжээнүүдийг дүгнэвэл соёл урлаг, өвлөн уламжлагчдийн оролцоо нэмэгдэж алдаршуулах түгээн дэлгэрүүлэх зэрэг ахиц дэвшил гарсан үзэж байна.

Дүгнэлтээр: Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь дунджаар 97,3 хувьтай дүгнэгдэж тодорхой үр дүнд хүрлээ.

ХШҮ СТАТИСТИК МЭДЭЭ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН *Назир* Б.НАДМИДЦЭРЭН